



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/296

Хэрлэн сум


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
газар-419 дүгээр нээлттэй хорих ангид
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравдугаар хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1.6, 4.1.1.6.1-д заасан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих ангийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор Зүүн бүсийн цахим хяналтын дэд төв байгуулахад шаардагдах тоног төхөөрөмж авах” зардалд зориулж 23,000,000 (хорин гурван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ